16	16	2022 оны I сард гарсан аваарийн мөрөөр Цахилган, РХА, Зуухны ажилтнуудад шаардлагатай сургалтуудыг зохион байгуулах	III сар	Сургалт, судалгааны мэргэжилтэн	1. ЦДҮС ТӨХК-тай хамтран 2022 оны II/28-III/10-ны хооронд 60 цагийн онол-даллага хосолсон сургалтыг ЗХАХТХ-н ахлах инженер З.Батзориг, НРХАИ Б.Тогтохжаргал, Х.Билгүүнбат нар Амгалан дулааны станц болон ЦДҮС ТӨХК-ийн сургалтын танхимд зохион байгуулсан. Сургалтад Нэгдсэн цехийн РХА-ийн инженер Д.Мөнхдөл, РХА-ийн монтёр Э.Олбаяр, А.Бямбадорж, Цахилгаанчин Н.Энхбаяр, П.Энх-Од нар хамрагдсан. 2.ТЭЦ-3-ийн үйлдвэрлэлийн албатай хамтран Зуухны горимын туршилт хийх, зуухны машинч, зуухны ашиглалтын инженер, зуухны ээлжийн дарга нарт зориулсан сургалтыг ТЭЦ-3-ын Үйлдвэрлэлийн албаны сургалтын инженер Н.Байтолов, Зуухны горимын машинч П.Батбаатар, С.Баатархүү нар 2022 оны 03 дугаар сарын 04 өдөр зохион байгуулсан. Сургалтанд Зуухан цехийн зуухны машинч, Зуухны Ээлжийн дарга, Зуухны ашиглалтын инженер, Станцын ээлжийн инженер нар хамрагдсан. 3. Түлшний машинчаар 12 ажилтан, 4. ЭХХТ-ийн сургагч багш Г.Ганбаярыг ажлын байран урьж авчран Зуухны ээлжийн дарга Б.Батбаяр, Э.Гансүх, Ж.Ганбат, Д.Дорждан, Зуухны машинч Г.Болортуяа, Н.Гомбосүрэн, Т.Толуй, Д.Мөнх-Эрдэнэ, Б.Санжаасүрэн, Д.Өлзийдагва, Э.Очирсүх, Зуухны туслах тоноглолын машинч Б.Мөнх-эрдэнэ, Б.Батбаатар, С.Хүрэлсүх, Г.Алт, насосны машинч Т.Лхамням, Г.Уртнасан, С.Сайханжаргал нарт 2022 оны 03 сарын 21-ны өдрөөс 04 сарын 01 өдөр хүртэл Зуухны машинчийн сургалт зохион байгуулж, 2022 оны 04 сарын 01 өдөр сургалтанд хамрагдсан 18 ажилтнаас шалгалт авч үнэмлэхжүүлсэн. 5. Химийн лаборант аппаратчины сургалтанд -3 ажилтныг тус тус хамруулсан.	100%

17	17	2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулах	ондоо	Сургалт, судалгааны мэргэжилтэн	1.Эрх олгох буюу ээлжит давтан сургалтанд - 122 ажилтан. 2.Мэргэжилтэн шүүмжлэх анхан шатны сургалтанд -34 ажилтан. 3.Мэргэжилтэн шүүмжлэх сургалтанд- 24 ажилтанг хамруулсан. 4.Олон нийтийг хамарсан сургалтанд-130 ажилтныг хамруулсан. 5.Дүүд байгууллага байгууллагын нийдвэрээр- 46 ажилтан буюу давхардсан тоогоор нийт 356 ажилтныг тус тус хамруулсан байна.	100%
18	18	Дулааны станцуудын нөхөрсөг спортын тэмцээний бэлтгэл хангах, оролцох	Ү-Ү1 сар	Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч	Ковид цар тахал гарсантай холбоотойгоор Дулааны станцуудын нөхөрсөг спортын тэмцээн зохион байгуулагдаагүй. Харин Амгалан дулааны станц ТӨХК, Багануурын дулааны станц ТӨХК-иудын хооронд 3 төрөлт нөхөрсөг уулзалт тэмцээн нийт 2022 оны 04 сарын 29-ний волейбол, сагсан бөмбөг, ширээний теннисний төрлөөр зохион байгуулсан.	100%
19	19	Эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн нэрэмжит спортын олон төрөлт тэмцээнд баг тамирчдыг оролцуулах	VII сар		Эрчим хүчний салбарын 100 жилийн ойн нэрэмжит Спортын их наадамд 6 төрөлд 44 тамирчдын бүрэлдэхүүнтэй оролцож, эрэгтэй волейболын төрөлд Хүрэл медаль авч, бусад төрөлд оролцсон баг тамирчид урд жилүүдийн тэмцээнд оролцсон амжилтуудаа ахиулж оролцлоо. Тэмцээнд нийт Эрчим хүчний салбарын 35 байгууллагын 1200 гаруй тамирчид оролцсоноос багийн нийлбэр дүнгээр 14-р байрт шалгарсан амжилтаар тэмцээнд оролцсон	100%
20	20	Эрчим хүчний салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойн нэрэмжит компанийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах	IV сар		Амгалан дулааны станцын ажилтнуудын дунд ҮЭ-ийн хороотой хамтран спортын 5 төрөлт тэмцээнийг 2022 оны 4-р сард амжилттай зохион байгуулж шилдэг баг, тамирчдаа тодруулж медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан.	100%
21	21	Ажилтнуудын дунд Волейбол, сагсан бөмбөгийн бооцоот тэмцээн зохион байгуулах	IX-X сарын хооронд		Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2022 оны волейболын бооцоот тэмцээнийг 2022.10.14-ний өдөр зохион байгуулж, тэмцээнд эрэгтэй 6 баг, эмэгтэй 4 баг тамирчид оролцсоноос А.Мөнх-Эрдэнэ ахлагчтай баг 1-р байр, Э.Одбаяр ахлагчтай баг 2-байр, М.Од-Эрдэнэ ахлагчтай баг 3-р байр, эмэгтэй багаас С.Сайханжаргал ахлагчтай баг 1-байр, Г.Уянга ахлагчтай баг 2-р байруудад тус тус шалгарсан.	100%
22	22	Компанийн тамирчдын биеийн тамирын болон тоглолтын чанартай хувцас, шкаф авах ажлыг Хангамжийн хэлтэстэй хамтран зохион байгуулах	III сар		Тамирчдын бэлтгэлийн хувцасны загвар, түүнд тавигдах шаардлага гаргаж удирдлагаар батлуулсан. Тамирчдын биеийн хэмжээ авч спорт хувцасны “Сомо” үйлдвэртэй гэрээ хийж 40 ширхэг бэлтгэлийн хувцас захиалж авсан. Харин тоглолтын хувцас, Спорт зааланд ажилчдын хувцас хийх шкаф зэргийн зардал хасагдсан.	100%
23	23	Өргөдөл гомдолыг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгөх	Жилдээ	Захирлын туслах	Компанийн захиргаанд ирсэн 346 өргөдөл гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд хариуг нь өгсөн.	100%
24	24	Тушаал, албан тоотыг журмын дагуу төлөвлөж, албажуулах. Ирсэн бичгийн биелэлтэнд нь хяналт тавьж, шийдвэрлэлтэнд нь хяналт тавих	Жилдээ	Бичиг хэргийн ажилтан	А тушаал 149, Б тушаал 313, ирсэн 527 албан тоот, явсан 685 албан тоотыг Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол шийдвэрлэх журмын дагуу төлөвлөж, албажуулан биелэлтэнд нь хяналт тавьж ажилласан.	100%
25	25	Цех, хэсэг, хэлтсүүдээс 2021 оны архивын баримтыг ХХНЖ-ын дагуу хүлээн авах.	I улиралд		Цех, хэсэг, хэлтсүүдээс ХХНЖ-ын дагуу 2021 онд хөтлөгдөж дууссан 228ш үдэж, хавтасласан архивын баримтыг байгууллагын архивт актаар хүлээн авсан. Баримтыг хадгалах хугацаагаар ангилан байнга, түр, 70 жил хадгалах бүртгэлд тус тус бүртгэсэн.	100%
26	26	Удирдлагын байнга хадгалах цаасан суурьтай хадгаламжийн нэгжүүдийн цахим программд оруулж дүүсгэх.	IV улиралд		Удирдлагын байнга, түр, 70 жил хадгалах нийт 290 баримтыг сканнердан, цахимжуулсан. ERP программд архивын цахим сан үүсгэж цахимжуулсан баримтыг цаасан суурьтай хадгаламжийн нэгжийн бүртгэсэн.	50%
27	27	Амгалан дулааны станц ТӨХК-ийн ХН-ийн бүртгэлийг дахин шинэчилж, БНШК-ийн хурлаар батлуулах.	II улиралд		Амгалан дулааны станц ТӨХК-ийн Архивын ХН-ийн бүртгэлийг дахин шинэчилж, БНШК-ийн хурлаар батлуулсан.	100%
28	28	Амгалан дулааны станц ТӨХК-ийн ХН-ийн данс бүртгэлийг Архивын ерөнхий газрын дэргэдэх БНШАЗК-оор батлуулах.	IV улиралд		Амгалан дулааны станц ТӨХК-ийн ХН-ийн данс бүртгэлийг Архивын ерөнхий газрын дэргэдэх БНШАЗК-оор батлуулахаар АЕГ-ын арга зүйч заавар зөвлөмж өгсөний дагуу хэрэгжүүлэн ажиллаж байна. Байнга хадгалах Түр хадгалах 70 жил	100%
29	29	Архивын өрөөнд төмөр хаалга хийлгэх, галын багаж, архивын шкаф нэмэж байрлуулах.	IV улиралд	Архивын ажилтан	2022 оны зардлын төлөвлөгөөнд оруулсан боловч хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн хүрээнд хасагдсан. 2023 оны зардлын төлөвлөгөөнд дахин оруулсан.	100%

ХОЁР. ХЯНАЛТЫН ХЭЛТЭС

30	1	ХАБЭА-н 1,2-р шатны үзэлт хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах	Тогтмол	ХАБЭА-н инженерүүд	Тайланг хугацаанд Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм-н 10.5.2-д заасны дагуу 1-р шатны үзэлтийг 1821 удаа хийж, 995 зөрчил илрүүлэн зөрчлийг 100%- 2-р шатны үзэлтийг 52 удаа хийж 105 зөрчил илрүүлж зөрчлийг 94%-тай арилгаж ажилласан	100%
31	2	ХАБЭА-н 3-р шатны үзэлт зохион байгуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах	Батлагдсан хуваарийн дагуу	ХАБЭА-н инженерүүд, Техник хяналтын инженер	Амгалан дулааны станцын цех, хэлтэс, хэсгийн ажлын байруудад эрүүл аюулгүй ажлын байр бий болгох, эрүүл ахуйн нөхцөлийг хангах, техник тоног тохөөрөмжийн найдвартай ажиллагааг хэрхэн хангаж ажиллаж байгааг хяналт тавих, заавар зөвлөмж өгөх зорилгоор 1 үйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдлын III шатны үзэлтийг 3 удаа явуулсан 170 зөрчил илрүүлэн бүртгэж 96.3% тай зөрчлийг арилгуулж ажиллав.	100%
32	3	Ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслэлийн хэрэглээнд хяналт тавих, гарсан зөрчлийг тухай бүр арилгуулах	Тогтмол	ХАБЭА-н инженерүүд	Ажилтнуудын ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгслэлийн хэрэглээнд хяналт тавьж ажилласан	100%
33	4	Зуух болон тоноглолын ашиглалтын заавар, дүрмийн шаардлагын биелэлтэд тогтмол хяналт тавьж, илэрсэн зөрчлийг шуурхай устгуулах	Тогтмол	Техник хяналтын инженер	Тоног тохөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, технологийн схемүүдийн бүрдүүлэлт, баталгаажуулалт, ашиглалтанд хагас жилд нэг удаа үзлэг шалгалт хийж илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулан ажилласан	100%
34	5	Ажлын байранд эргэлт, шалгалт хийж илэрсэн зөрчлийг бүртгэж, арилгуулах арга хэмжээ авах	Тогтмол	ХАБЭА-н инженерүүд,	Ажлын байранд эргэлт, шалгалт хийж илэрсэн зөрчлийг бүртгэж, арилгуулах арга хэмжээ авч ажилласнаар ажилтануудыг осолд нэрвэл дэхээс урьчилан сэргийлэж 2022 онд осол болон осол дөхсөн тохиолдол гараагүй.	100%
35	6	Батлагдсан графикийн дагуу ажлын байруудад эрүүл ахуйн хэмжилт хийх	Хуваарийн дагуу	Техник хяналтын инженер	Батлагдсан графикийн дагуу ажлын байруудад эрүүл ахуйн хэмжилтыг гэрэлтүүлэг, тоосжилт зэргийг хэмжиж байна. Хэмжилтийн дүнгээр ажил сайжруулах албан шаардлагыг холбогдох цехүүдэд өгч ажиллав	100%
36	7	Өдөр тутам болон сарын давтан зааварчилгаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах	Тогтмол	ХАБЭА-н инженерүүд,	Өдөр тутам болон сарын давтан зааварчилгаанд хяналт тавьж ажилласан ба эхний хагас жилийн байдлаар 1458 ажилтанд , давтан зааварчилгааг 639 ажилтанд өгсөн байна.	100%
37	8	Шинээр ажилд орсон ажилтанд урьдчилсан зааварчилгаа өгч, журнал хөтлөлт хийх	Тухай бүрт	ХАБЭА-н инженерүүд,	2022 онд шинээр ажилд орсон болон ажлын байр өөрчлөгдсөн 65 ажилтанд давхардсан тоогоор урьдчилсан зааварчилгаа өгч, журналд хөтлөлт хийн ажилласан.	100%
38	9	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх	III сар	ХАБЭА-н инженерүүд	Амгалан дулааны станц ТӨХК-ийн 40 ажлын байранд ажилладаг 143 ажилтныг Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 тоот тушаалаар батлагдсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам” болон ХАБЭА-н Үндсний хорооны 2016 оны 05 сарын 30-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор батлагдсан “ Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж”-ийн хүрээнд, мөн Зуухан цех, ТДЦех, Нэгдсэн цех, АХММХэсэг, Хяналтын хэлтэс болон Инженерийн хэсгийн ажлын байруудад ХАБЭА-н тухай хуулийн 28.1.4-д заасан “Ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдлийн үнэлгээ хийлгэнэ” гэсэн заалтийг дагуу Даблюу Эйч Эй ХХК-иар Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгүүлсэн.	100%
39	10	Гамшгийн эрсдлийн үнэлгээ хийлгэх	IV сар	ХАБЭА-н инженерүүд	Монгол улсын гамшгаас хамгаалах тухай хуулийн 7.1 дэхь заалтын дагуу гамшгийн эрсдлийн нарийвчилсан үнэлгээг 6 нэр төрлийн ажил дээр хийлгэх ажлыг зохион байгуулж ажилласан. Гамшгийн эрсдлийн нарийвчилсан үнэлгээг “Уст бэлчир” ХХК хийж гүйцэтгэсэн бөгөөд тус компаний захирал Ш.Мөнхтулга үнэлгээний тайланг тайлагнав.	100%
40	11	Ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд даатгуулах	II сар	ХАБЭА-н инженерүүд	Амгалан дулааны станц ТӨХК нь 150 ажилтан Нийгмийн даатгалын тухай хуулийн 4.6, заалтийн хүрээнд гэнэтийн ослын даатгалд хамруулан Миг даатгал ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажилласан ба дараах 5 ажилтнуудын нөхөн төлбөрийн хүсэлт болон холбогдох материалуудыг бүрдүүлж нийт 2250000 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан.	100%
41	12	Жилийн ажлын тайлан, төлөвлөгөө гаргах	I сар	ХАБЭА-н инженерүүд	2022 оны жилийн ажлын тайлан, 2023 оны жилийн төлөвлөгөө гаргаж ЗУХэлтэс өгсөн.	100%
42	13	Сарын ажлын тайлан, төлөвлөгөө гаргах	Сар бүр	ХАБЭА-н инженерүүд	2022 оны сарын ажлын тайлан, төлөвлөгөөг тогтмол гарган батлуулж ажилласан.	100%
43	14	Ажлын байрны галын аюулгүй байдалд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах	Тогтмол	ХАБЭА-н инженерүүд	Ажлын байрны галын аюулгүй байдалд хяналт тавих, илэрсэн зөрчлийг тухай бүр арилгуулан ажилласан.	100%
44	15	Галын анхан шатны багаж хэрэгслэлийн хэрэглээнд хяналт тавьж ажиллах	Тогтмол	ХАБЭА-н инженерүүд	Галын анхан шатны багаж хэрэгслэлийн хэрэглээнд хяналт тавьж ажиллаж байна.	100%
45	16	Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	V сар	ХАБЭА-н инженерүүд	БЗДүүргийн онцгой байдлын хэлтэст галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах хүсэлт явуулсаны үр дүнд 2022.06.09 ны өдөр № 0003307 дугаартай галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулав.	100%
46	17	Галын тактик сургуулилт зохион байгуулах	IX-X сар	ХАБЭА-н инженерүүд	БЗДүүргийн онцгой байдлын хэлтэсийн үйл ажиллагаанаас болж хийгдээгүй	0%
47	18	I-сараас дээш хугацаанд ажлаас хөндийрсөн ажилтнуудад мэдлэг сэргээх сургалт орох	IX сар	ХАБЭА-н инженерүүд	Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрэм-н 12.13.4.1 заалтын дагуу I-сараас дээш	100%

28

48	19	Гаднаас дотоо хугацаанд ажлаас хөндийрсөн ажилтануудаас шалгалт авах	IX сар		Хугацаанд ажлаас хөндийрсөн 138 ажилтануудад мэдэлгэ өргөх сургалт орж шалгалт авсан	100%
49	20	ААЦ, ГАЦ, ГАБ-ын ээлжит шалгалт авах	IX-X сар	ХАБЭА-н инженерүүд, Техник хяналтын инженер	Ээлжит шалгалт авах 100% Ашиглалтын 4-н ээлжийн 108 ажилтан, одрийн ИТА 30, нийт 140 ажилтан шалгалт өгөхөөс 15 ажилтан дагалдан, зэрэг нэмсэн, жинхэнэ, ЦДҮС-д шалгалт өгсөн шалтгаанаар чөлөөлөгдөж 140 ажилтан өгөв. Шалгалтанд 135 ажилтан тэнцэв. • ИТ Ажилчдаас 32 хүн өгч 32 ажилтан тэнцэв. • Ашиглалтын 1-р ээлж 27 ажилтан өгч 26 хүн тэнцэв. • Ашиглалтын 2-р ээлж 27 ажилтан өгч 25 хүн тэнцэв. • Ашиглалтын 3-р ээлж 27 ажилтан өгч 26 хүн тэнцэв. Ашиглалтын 4-р ээлж 27 ажилтан өгч 26 хүн тэнцэв.	100%
50	21	Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд тодотгол хийлгэх	III сар	ХАБЭА-н инженерүүд	"Эко бүтээмж групп" ХХК -тай хамтран ажиллаж 2022 оны БОМТодовлоогийн хэрэгжилтэнд мониторинг хийх гэрээг бэлэн болгож байгуулав.	100%
51	22	ХАБЭА-н мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор уралдаант тэмцээн зохион байгуулах	IV сар		Цар гахайн дэгдэлт их байсны улмаас хойшлогдсон.	0%
52	23	Техник ашиглалтын паспортуудын хөтлөлтөнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах.	Тогтмол	Техник хяналтын инженер	Станцын хэмжээнд хөтлөгдөж байгаа техник ашиглалтын паспортуудад сар бүр хяналт тавин, тухай бүр илэрсэн зөрчлүүдийг арилгуулан ажиллаж байна. 2022 оны 9 дүгээр сарын байдлаар: 1. ЗЦех 96 ширхэг ТАП-аас 15 зөрчил 2. ТДЦехийн 71 ширхэг ТАП-аас 10 зөрчил 3. Цахилгааны хэсгийн 262 ширхэг ТАП-аас ямар нэгэн зөрчилгүй. 4. Хими хэсгийн 40 ширхэг ТАП-аас ямар нэгэн зөрчилгүй. 5. Авто хэсгийн 9 ширхэг ТАП-аас 9 ширхэг зөрчил тус тус илрүүлж тухай бүр зөрчлүүдийг арилгуулан ажиллаж байна.	100%
53	24	Зуух №1,2,3-т техникийн магадлагаа хийлгэх	IX сар		Зуух №1,2,3-т техникийн магадлагаа хийлгэсэн.	100%
54	25	Даралтат савнуудад техникийн магадлал хийлгэх	IX сар		"Армос" ХХК-тай хамтарч Зуухан цехийн 12 ширхэг, хими хэсгийн 2 ширхэг хийн бак буюу даралтат савуунуудын хийн сорилт гүйцэтгэж, техникийн магадлагаа гаргуулсан. Хийн сорилын үеэр ямар нэгэн үл тохирол гарч ирээгүй.	100%
55	26	Өргөх зөөх машин механизмд техникийн магадлал хийлгэх	III сар		"Мон Кран" ХХК-тай хамтарч Зуухан цехийн 24, түлш дамжуулах цехийн 15 нийт 39 ширхэг өргөх зөөх механизм (тайл), авто хүнд машин механизмийн хэсгийн мяти кранд техникийн магадлагаа хийсэн. Үүнд: • Зуухан цехийн 14 ширхэг өргөх зөөх механизмаас 6 ширхэг нь тэнцээгүй. • Түлш дамжуулах цехийн 25 ширхэг өргөх зөөх механизмаас 4 ширхэг нь тэнцээгүй байна.	100%
56	27	Их болон урсгал засварын ажилд хяналт тавьж ажиллах	V-IX сар		1. ЗЦехийн 63 ширхэг их болон урсгал засварын акт гарахаас 15 акт ширхэг дутуу 2. ТДЦехийн 22 ширхэг засварын акт гарахаас 2 акт ширхэг дутуу 3. Хими хэсгийн 34 ширхэг акт гарахаас 6 ширхэг акт дутуу 4. Цахилгааны хэсгийн 157 ширхэг акт 5. ДХХА-н хэсгийн 10 ширхэг акт 6. АХММ-ийн хэсгийн 9 ширхэг акт тус тус бүрэн хийгдсэн байна.	100%
57	28	Авто машин механизм болон хүнд даацын машин механизмын тоноглолын бүрэн бүтэн байдалд хяналт тавих	Тогтмол		2022 оны 9 дүгээр сарын 22 өдөр АХММ-ийн хэсгийн хүнд даацын 5 ширхэг тээврийн хэрэгсэлийн бүрэн байдалд үзлэгийн хуудсын дагуу үзлэг хийсэн. Мөн тухайн үзлэгийн хуудасны дагуу АХММ-ийн хэсгийн механик инженер болон ээжлийн жолооч нар ээлж солилцдог.	100%
ГУРАВ. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТЭС						
58	1	Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд НББОУС, холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг мөрдөж ажиллах, НБББББ-ийн хөгжүүлэлт, сайжруулалт, гарын авлагын хэсгийг боловсруулах	Жилийн турш		Батлагдсан НБББББ-т холбогдох дүрэм, журам, заавар, зарчим болон практикт тохиолдсон үйл явдлуудыг хэрхэн бүртгэх талаар нэмэлтээр тусгаж, гарын авлага, журмуудыг боловсруулан Гүйцэтгэх захирлын А/56, А/84 дугаар тушаалуудаар Кассын үйл ажиллагааны журам, Цалингийн журмыг батлуулан мөрдөж ажиллаж байна. Мөн НБББББ-ийн тусгай бодлогыг Гүйцэтгэх захирлын А/115 дугаар тушаалаар батлуулан санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.	100%

59	2	Омч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих, хагас жил, жилийн эцсийн тооллогыг зохион байгуулах, тооллогын явцад арга зүйгээр хангаж ажиллах, тооллогын шийдвэрийн холбогдох эрх бүхий газруудад хүргүүлж, шийдвэрлүүлэх	Тухай бүр	Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	Омч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтанд тухай бүр хяналт тавьж ажилласан бөгөөд Хагас жилийн тооллогыг 1 гүйцэтгэх захирлын А/97 дугаар тушаалаар томилогдсон комисс 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдрөөс 24-ний өдөр, жилийн эцсийн тооллогыг 1 гүйцэтгэх захирлын А/144 дугаар тушаалаар томилогдсон комисс 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 25-ний өдрүүдэд зохион байгуулж ажилласан. Омч хамгаалах байнгын зөвлөлөөр 6 асуудал хэлэлцэж, 3 асуудлыг ЭХЯ-нд хүргүүлж, автомашины дуудлага худалдаа зохион байгуулах 1 асуудал шийдвэрлэгдэж зохион байгуулагдагдсан байна.	100%
60	3	Жил, сарын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл гаргаж батлуулах, хагас жил, жилийн эцсийн тайлан бичиж тайлагнах, баталгаажуулах	Тухай бүр		2022 оны хэлтсийн жилийн үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөг 2022.01.24-ний өдөр батлуулсан мөрдөж ажилласан бөгөөд хагас жил болон жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийг тайлагнасан.	100%
61	4	Хагас жил, жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргаж Сангийн яам, ЭХЯ-нд цахимаар шивэх болон ЭХЯ, ЭХЗХ, аудитын компанид хүргүүлэх	Сар бүрийн 07.20, 02.10-ны дотор		2022 оны жилийн эцсийн тайланг 2023 оны 2 дугаар сарын 10-ны дотор Сангийн яам, ЭХЯ, Мэдээлэл аудит ХХК-д хүргүүлсэн. Хагас жилийн санхүүгийн тайланг бэлтгэж, Сангийн яам, Эрчим хүчний яамны цахим хуудсанд хугацаанд нь шивсэн бөгөөд ЭХЯ, ЭХЗХ, Мэдээлэл аудит ХХК-д албан бичгээр 2022.07.25-ны өдөр хүргүүлсэн.	100%
62	5	ААНОАТ, ҮХХТ, ус ашигласны төлбөрийн тайлан, газрын төлбөрийн тайлан гаргаж, татварын албанд цахимаар илгээх, хянуулж баталгаажуулсан байх	Сар бүрийн 02.10-ны дотор		2022 оны жилийн эцсийн ААНОАТ, ҮХХТ, ус ашигласны төлбөр, газрын төлбөрийн тайланг хуулийн хугацаанд татварын албанд 2023.02.10-ны өдөр цахимаар илгээсэн. Хагас жилийн байдлаар ААНОАТ-ын тайланг хуулийн хугацаанд бэлтгэж, 2022.07.25-ны өдөр цахимаар илгээсэн.	100%
63	6	НОАТ-ын тайланг гаргаж, татварын албанд цахимаар илгээх. Үүнд: сар бүрийн 7-ны дотор харилцагч байгууллагуудыг цахим сайтад гүйлгээг илгээх талаар шаардлага тавих, тулган баталгаажуулах	Сар бүрийн 10-нд	Нягтлан бодогч нар	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг хуулийн хугацаанд буюу сар бүрийн 10-ны дотор тайлагнаж, татварын албанд цахимаар илгээсэн.	100%
64	7	2022 оны техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинг хангаж ажиллах	Тухай бүр	Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч, Эдийн засагч	2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, төлөвлөгөөт орлогыг 2,184.4 сая төгрөгөөр буюу 9.9 хувиар нэмэгдүүлж, 24,192.3 сая төгрөгийн орлоготой, төлөвлөгөөт зардлыг 1,719.4 сая төгрөгөөр буюу 5.5 хувиар нэмэгдүүлж, 32,816.0 сая төгрөгийн зардалтай, төлөвлөгөөт алдагдлыг 325.4 сая төгрөгөөр буюу 3.6 хувиар бууруулан 8,623.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан.	100%
65	8	2021 оны хэлтсийн ажлын тайлан боловсруулж, танилцуулга бэлтгэх, хянуулах	Сар бүрийн 01.28-ны дотор		2022.02.18-ны өдөр 2021 оны хэлтсийн ажлын тайланг боловсруулж, танилцуулга бэлтгэн Захиргаа Удирдлагын хэлтэст хүргүүлсэн.	100%
66	9	Дээд газрын хяналт шалгалт, аудит хийхэд мэдээллээр хангаж ажиллах, үр дүнг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах	Тухай бүр		Үндэсний Аудитын газар, Мэдээлэл аудит ХХК-тай гурвалсан гэрээ байгуулсаны дагуу 2021 оны жилийн эцэс, 2022 оны завсрын аудит санхүүгийн тайлан тэнцэлд аудит хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан. Үндэсний аудитын газраас зохион байгуулсан гүйцэтгэлийн аудитад шаардлагатай материалыг бүрдүүлж, 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хүргүүлсэн.	100%
67	10	2022 оны худалдан авалтын төлөвлөгөөнд хяналт тавьж ажиллах	Жилийн турш		2022 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тухай бүр хяналт тавьж ажилласан.	100%
68	11	ЭХЯ, ТӨБЗГ, ЭХЗХ-ны ажлын хэсэгт 2023 оны техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний санал авч нэгтгэн танилцуулах, боловсруулах, батлуулах	XII сар		2023 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний саналыг нэгтгэн 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжиж, Эрчим хүчний яам болон Эрчим хүчний зохицуулах хороонд 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүлсэн. Тус саналыг ажлын хэсэг хянан, Эрчим хүчний сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан болно.	100%

69	12	ЭХЗХ-нд 2022 онд мөрдөж ажиллах дулааны эрчим хүчний үнэ тарифын санал хүргүүлэх, батлуулах, мөрдөж ажиллах	Тухай бүр	Эдийн засагч	Эрчим хүчний зохицуулах хороонд 2022 онд мөрдөж ажиллах дулааны эрчим хүчний үнэ тарифын саналыг 2021 оны 12 дугаар сард хүргүүлж, 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 22 дугаар тогтоолоор батлуулан мөрдөж ажилласан. 2022 оны батлагдсан нийт зардлын санхүүжүүлэх хэмжээнд тариф батлагдаагүйгэй холбогдуулан зуны сүд зогсолтын хугацаанд үйл ажиллагааг санхүүжүүлэх талаар 05 дугаар сарын 03-ны өдөр үнэ тарифын санал хүсэлтүүдийг удаа дараа хүргүүлж, 05 дугаар сарын 19-ны өдрийн 382 дугаар тогтоолоор дулааны эрчим хүчний чадлын тариф батлуулан мөрдөж ажилласан. 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдөр станцын өргөтгөлийн санхүүжилттэй холбогдуулан 5 жилийн үнэ тарифыг батлуулах хүсэлтийг хүргүүлж, 07 дугаар сарын 08-ны өдрийн 444 дүгээр тогтоолыг батлуулсан. 2022 оны 4 дүгээр улиралд мөрдөх үнэ тарифын саналыг 09 дүгээр сарын 19-ний өдөр хүргүүлсэн боловч шийдвэрлэгдэнгүй. 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдөр нүүрс, төмөр замын тээвэр, цахилгаан эрчим хүчний үнэ тарифын нэмэгдлийг дулааны эрчим хүч худалдах тарифт тусгах хүсэлт хүргүүлж, 12 дугаар сарын 16-ны өдрийн 675 дугаар тогтоолыг батлуулан мөрдөж ажилласан	100%
70	13	ЭХЗХ-нд санхүүгийн тайлангийн хавсралт тайлангуудыг гаргаж, хүргүүлэх, хянуулах, баталгаажуулах	Улирал бүр	Эдийн засагч	Эрчим хүчний зохицуулах хороонд хагас жилийн санхүүгийн тайлангийн хавсралт тайлан, мэдээг бэлтгэж, 2022 оны 07 дугаар сарын 25-ны дотор хүргүүлсэн. 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хавсралт мэдээг 02 дугаар сарын 14-ны өдөр хүргүүлсэн	100%
71	14	ДЭХ-ний орлогыг хугацаанд нь төвлөрүүлэх	Сар бүр		Дулааны эрчим хүчний төлбөрийг гэрээнд тусгасаны дагуу сар бүр бүрэн төвлөрүүлж, жилийн эцсийн байдлаар УБДС ТӨХК-аас авах 661.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлгүй байна.	98%
72	15	Гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах	Тухай бүр		2022 онд нийт 136 гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, гэрээг дүгнэн акт үйлдэж баталгаажуулж ажилласан	100%
73	16	Бараа материал хүлээн авалт, зарцуулалтад хяналт тавьж, бараа материалын тайлан гаргаж, баталгаажуулах	Тухай бүр	Бараа материалын нярав, Бараа материалын нягтлан бодогч	Бараа материалын хүлээн авалт, зарцуулалтад тухай бүр хяналт тавьж, бараа материалын тайланг сар бүр бэлтгэж, баталгаажуулж ажилласан. 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр анхан шатны баримтын бүрдэл хангасан нийт 14,409.7 сая төгрөгийн бараа материал орлогод бүртгэж, 14,220.6 сая төгрөгийн бараа материалыг зарлагын бүртгэл хийгдсэн байна.	100%
74	17	Төмөр замын тээврийн хөлсний тайлан тооцоо гаргаж, үлдэгдлийг баталгаажуулах, нүүрсний уурхайнуудын тооцоо гаргаж, тооцоо нийлэх, шаардах хуудас хянах, маркшейдерийн дүнтэй тулгах	Тухай бүр	Бараа материалын нягтлан бодогч	Сар бүр тээврийн хөлсний тайлан тооцоо хийж, УБТЗ ХНН-тэй тооцоо нийлж, нүүрсний уурхайнуудтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулан тайлан бэлтгэж ажилласан.	100%
75	18	Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцоолол хийж, журнал бичилт үүсгэж, тайлан гаргах, хагас жил, жилийн эцсээр татварын зорилгоор байгуулах элэгдлийн тооцоо хийх	Тухай бүр	Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч	Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг сар бүр холбогдох журмын дагуу тооцож, журналын бичилт үүсгэн, хагас жилийн байдлаар татварын зорилгоор элэгдэл байгуулан, зөрүүг зохицуулах тайлан гаргасан.	100%
76	19	ТӨБЗГ-т өмч эзэмшүүлэх гэрээ дүгнүүлэх, ТӨБЗГ-ын хөрөнгийн программд үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тухай бүр нэмж оруулах, мэдээлэх	Тухай бүр		ТӨБЗГ-ын улсын үзлэг тооллогыг зохион байгуулж, цахим тооллогын программд 2022.06.15-ны өдрийн дотор оруулж, 2022.09.12-ны өдөр тайланг хүргүүлж, баталгаажуулсан. Өмч эзэмшүүлэх гэрээг маягтын дагуу хүргүүлж, 2022.03.25-ны дотор дүгнүүлсэн.	100%
77	20	Шатахууны тайлан тооцоо гаргаж, шатахуун түгээх станцтай тооцоо нийлэх,	Сар бүрийн 5-ны дотор	Үндсэн хөрөнгийн нягтлан бодогч	Шатахууны тайлан тооцоог сар бүрийн эцэст бэлтгэж, шатахуун түгээх станцтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж ажилласан.	100%
78	21	Нийгмийн даатгалын тайланг боловсруулж, цахим хуудсанд илгээж, баталгаажуулах	Сар бүрийн 5-ны дотор		Нийгмийн даатгалын тайланг боловсруулж, сар бүрийн тайланг дараа сарын 05-ны дотор цахим хуудсанд илгээж, баталгаажуулж ажилласан.	100%
79	22	Ажилтнуудын цалин бодож, банкуудад жагсаалт хүргүүлэх, олгох	Сар бүрийн 15, 30-нд		Ажилтнуудын цалинг сар бүрийн 15, 30-ны өдрүүдэд тооцож, банкуудад жагсаалт хүргүүлэн хугацаанд нь олгож ажилласан.	100%
80	23	ХХОАТ, ТТ-11, ТТ-12 тайланг улирал бүр гаргаж, харъяа татварын хэлтэст тушааж тооцоог баталгаажуулах	Улирал бүр		ХХОАТ, ТТ-11, ТТ-12 тайланг улирал бүр бэлтгэж, харъяа татварын хэлтэст хуулийн хугацаанд цахимаар илгээж, тооцоог баталгаажуулж ажилласан.	100%
81	24	Шилэн дансанд мэдээллүүд тухай бүр оруулах, тайланг холбогдох газруудад хүргүүлэх	Сар бүрийн 7-ны дотор		Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, цахим хуудсанд байршуулах бүх мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж ажиллаж байна. Мөн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг сайжруулах үйлдвэрийн захирлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/90 дугаар тушаалаар Шилэн дансны цахим хуудасны мэдээллийг бэлтгэх, байршуулах албан тушаалтнуудын жагсаалтыг шинэчлэн батлан, мөрдөж ажиллаж байна.	100%

82	25	ТӨХХ-нд тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлт гаргаж хүргүүлэх	Сар, улирал, жилээр	Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	ТӨХХ-нд 2022 оны тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлттэй холбоотой санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн биелэлт, 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Инженерийн хэсэгт хүргүүлсэн.	100%
83	26	Харьяа дээд байгууллагуудад холбогдох мэдээ, тайлан, шаардсан судалгаа, тооцоог хугацаанд нь хүргүүлэх	Тухай бүр		Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани Ди Би Эм Лимит ХХК-д станцыг 1-зуухаар орлогоо тослийн санхүүжилттэй холбоотой тайлан, мэдээ, судалгаа тооцоог тухай бүр хүргүүлж ажиллан, 2022 оны 10 дугаар сарын 28-н өдөр Санхүүгийн түрээсийн гэрэм байгуулж, баталгаажуулсан. Нийцэлтийн захиргааны хэргийн анхан шатны шүүхийн захирамжийн дагуу томилогдсон шинжээчид шаардлагатай нэмэлт материалыг 2022.04.11-ний өдөр хүргүүлсэн. 2022.04.29-ний өдөр хуралд оролцож, нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн шийдвэрлүүлсэн.	100%
ДОРОВ. ИНЖЕНЕРИЙН ХЭСЭГ						
84	1	ДҮГ ТӨХК-иас өгсөн дулаан үйлдвэрлэлийн горим, ачааллыг барьж ажиллах, хяналт тавих, хэвийн горимоор ажиллуулах	Халаалтын улиралд	Ээлжийн инженер, Горимын хяналт, тооцооны инженер	2022 оны 1-р сард даралтыг 8.0/2.0 ата температурыг 119.5/56°C, 2-р сард даралтыг 8.0/2.0 ата, температурыг 119.5/54.3°C, 3-р сард даралтыг 7.8/2.0 ата, температурыг 100.6/47.6°C, 4-р сард даралтыг 7.5/2.0 ата, температурыг 90.25/43.95°C, 9-р сард даралтыг 7.0/2.0 ата, температурыг 86.98/46.03°C, 10-р сард даралтыг 7.5-8.0/2.0 ата, температурыг 90.8/45.16°C, 11-р сард даралтыг 8.0/2.0 ата, температурыг 101.7/49.36°C, 12-р сард даралтыг 8.5/2.0 ата, температурыг 120.58/55.62°C-аар тус тус барьж ажилласан.	100%
85	2	Дулаан үйлдвэрлэлийн горим төлөвлөж батлуулах, хоногийн үзүүлэлтийн дулаан, нүүрс, цахилгаан, ус, үнсний тооцоолол хийх, дүгнэлт гаргах.	I-IV-р сар, IX-XII-р сар		Горимын тооцоолол хийж 2022 онд 809,306 Гкал дулааны эрчим хүч үйлдвэрлэж, 795,366 Гкал дулааны эрчим хүч түгээх төлөвлөгөө гарган мөрдөж ажилласан. Гүйцэтгэл: 2022 онд төлөвлөгөөгөөр 809,306 Гкал дулаан үйлдвэрлэхээс 841,820 Гкал дулаан үйлдвэрлэж 104% хувиар биелэгдсэн, 795,366 Гкал дулаан түгээхээс 826,932 Гкал дулаан түгээж 103.97%-иар биелэгдсэн байна. Нүүрс төлөвлөгөөгөөр 273,889 тн зарцуулахаас 315,443 тн зарцуулж нийт 32,922 тонн үнс гарсан, цахилгаан төлөвлөгөөгөөр 27,613 мян кВт, гүйцэтгэлээр 28,852 мян кВт цахилгаан зарцуулсан байна.	100%
86	3	Химн ус бэлтгэл горим, нүүрс, ус, цахилгаан зарцуулалтын үйлдвэрлэлтэй уялдуулан төлөвлөж батлуулах /дулаан, нүүрс, цахилгаан, ус, үнсний тооцоолол хийх, дүгнэлт, хоногийн үзүүлэлт гаргах/.	I улиралд		Сүлжээний усны зарцуулалтын төлөвлөгөө дундажаар 2751 тн, гүйцэтгэл 2552 тн байсан бод 12 сард хамгийн их зарцуулалт гүйцэтгэлээр 3855 тн/ цаг хүрч нэмэгдсэн. Нэмэлт усны зарцуулалтын төлөвлөгөө - 274345 тн, гүйцэтгэл - 135048 тн, УСУГ-аас - 21241 тонн ус, Худагаас - 146812 тонн, Хөрсний болон голоос 18360 тонн ус зарцуулсан байна.	100%
87	4	Өдөр тутмын наряд, шийдвэрээр орж байгаа ажилд зөвшөөрөл олгож ХАБЭА-н зааврын мөрдөлтөнд хяналт тавьж, үйлдвэрлэлийн осол, зөрчилгүй ажиллах	Жилдээ	Ээлжийн инженер	Зуухан цех 246, ТДЦ-75, Цахилгааны хэсэг 19, ДХХА хэсэг 6, Авто 1, Хими 11 нийт 358 ажилд өдөр ажлын нярадал зөвшөөрөл өгч хяналт тавьж ажилласан ба уг ажлуудыг үйлдвэрийн үйл ажиллагааны хэвийн, хүндрэл учруулахгүй нөхцөлийг хангаж ажиллуулсан.	100%
88	5	Тоноглолын эргэлт шалгалт тогмол хийж хэвшүүлэн илэрсэн гэмтэл зөрчлийг шуурхай устгуулж төлөвлөгөөт бус зогсолт гаргахгүй байх.	Халаалтын улиралд		Жилийн байдлаар нийт 102 гэмтэл бүртгэгдэж гэмтлүүдийг тухай бүрд нь шуурхай арилгахад хяналт, шаардлага тавьж ажиллав.	100%
89	6	Сүлжээний нэмэлт усны химийн горимд хяналт тавьж ажиллах, нэмэлт усны дулааны тооцоолол гаргах.	Жилдээ		Сүлжээний нэмэлт усны химийн горимд хяналт тавьж ажилласан. Нэмэлт усны зарцуулалтын төлөвлөгөө - 274345 тн, гүйцэтгэл - 135048 тн буюу 139297 тонн усыг бууруулж ажилласан байна. Нэмэлт усны халаасан дулааныг 2022 оны 03-р сард 404 Гкал, 04-р сард 513 Гкал, 09-р сард 231 Гкал, 10-р сард 563 Гкал, 11-р сард 841 Гкал, 912 Гкал, нийт 3464 Гкал дулааныг УБДС ТӨХК-тай тооцоолол хийгдсэн байна.	100%
90	7	Станцын дотоод хэрэгцээний ЦЭХ-ний оргил ачааллын хэрэгцээг бууруулах, ажил үйлчилгээг зохицуулж ажиллах, хэмнэлт гаргах, үр ашиг сайжруулах	Жилдээ		17:00-22:00 цагийн оргил ачаалалын үед түлш дамжлага болон үндсэн тоноглолуудыг ажилд залуулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авч цахилгаан эрчим хүч бага зарцуулж ажилласан.	100%
91	8	Галын аюулаас урьдчилан сэргийлэх болон аваарь эсэргүүцэх, осол эсэргүүцэх дасгал хийж дадлагажих	Жилдээ		Жилийн байдлаар осол эсэргүүцэх дасгал 2 удаа, аваарь эсэргүүцэх дасгал 4 удаа хийж ажилчдыг дадлагажуулсан.	100%
92	9	Уурхайнуудтай нүүрс худалдан авах гэрээ байгуулж хэрэгжилтийг хангах, гэрээ дүгнэх, дулаан гаргах чадварыг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах	Халаалтын улиралд	Ахлах инженер	Жилийн хугацаанд 300587 тонн нүүрс төлөвлөж гэрээ байгуулан гүйцэтгэлээр Багануур ХК-30823.18, "Цэцэнс майнинг энд энержи" ХХК-87466, "Монкоул петро майнинг" ХХК-72672, "Хүрээдэл" ХХК-9782.1, Шивээ-Овоо ХК-105396 тонн, бүгд-306139.07 тонн нүүрсийг татан авч 101.85%-ийн биелэлттэй сан Багануур ХК, Цэцэнс майнинг энд энержи ХХК, Шивээ-Овоо ХК-иудын нүүрсний гэрээ дүгнэв. Монкоул петро майнинг ХХК-ийн нүүрсний чанар, фракц нь гэрээний шаардлага хангаагүй учир гэрээг 2023 оны 01 дүгээр сарын 02-ны байдлаар тасалбар болгож цуцлав.	100%

93	10	УБДС ТӨХК болон бусад хэрэгдэгтэй дулаан борлуулалтын гэрээ байгуулах, дүгнэх	Халаалтын улиралд	Ахлах инженер, Гормын хяналт, тооцооны инженер	УБДС ТӨХК-тай 11.13.19.2022 тоот гэрээ, Монгол ташуур ХХК-тай 100.2021 тоот гэрээ, Наху баян ХХК-тай 106.2021 тоот гэрээ тус тус байгуулж, гэрээг дүгнэн тооцоог дуусгав. УБТЗ ХНН-ийн БЗАУ ангитай дулааны эрчим хүч худалдах, худалдан авах 109.2022 тоот гэрээг 2022 оны 10-р сарын 07-ны өдөр УБДС ТӨХК-тай 2022-2027 онуудад дулааны эрчим хүч худалдах, худалдан авах 120.2022 тоот гэрээг 2022 оны 11-р сарын 10-ны өдөр тус тус байгуулан ажиллаж байна	100%
94	11	УБТЗ ХНН-тэй вагон таталт, тавилт, салбар зам арчлалтын гэрээ байгуулах, дүгнэх, сар бүр вагоны хуваарь гаргаж батлуулах, вагон ашиглалтын тооцоо хийх	Халаалтын улиралд	Ахлах инженер, Эрчим хүчний хэмнэлтийн менежер	УБТЗ ХНН-ийн сэлгээний зүтгүүрээр вагон тавьж өгөх, татаж авах тухай гэрээний сунгалтын нэмэлт гэрээ ГП 21/249-1, 34/2022 тоотгоор сунгав. Салбар зам арчлалтын гэрээг ОI/22/664, 10/2022 тоотгоор шинээр байгуулж хэрэгжилтийг хангаж ажилласан. Сар бүрийн эцсээр дараа сарын вагоны төлөвлөгөө хуваарь гаргаж УБТЗ ХНН-ийн орлогч даргаар батлуулж сар бүр вагон ашиглалтын тооцоо хийсэн.	100%
95	12	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт, урсгал засварын ажилд хяналт тавьж гүйцэтгэлийг хангуулах, тайлан гаргах, ЭХЯ-д мэдээл өгөх.	V-XII сар	Ахлах инженер, Ээлжийн инженер	Жилийн байдлаар Их засвараар зуух №2.3-ын засварын ажил болон хүнд даацын болон шуурхай ажиллагааны машин механизмын бүрэн ээлж солих ажил тус тус 100% биелэлттэй, ТЗБАХ-ын Зуухны орох усны ДУ500-н гар хаалтруу гарах шат тавцан хийх, 100 Гкал дулаанаар өргөтгөх ТЭЗҮ боловсруулах, Хоосон вагон шилжүүлэх хэсэгт угаалгын усны шугам болон хаягдал ус зайлуулах шугам хийх ажлууд 100% гүйцэтгэлтэй, Хөрөнгө оруулалтаар төлөвлөгдсөн 21 ажил 100% худалдан авалт хийгдэж, нийт дүнгээр 29 нэр төрлийн ажил 100%-ийн гүйцэтгэлтэй байна.	100%
96	13	Зуухны суурилагдсан хүчин чадлыг 100Гкал-аар нэмэгдүүлж нэг зуухаар өргөтгөх ТЭЗҮ хийх шаардлагатай материал бүрдүүлж өгөх, ЭХЯ-тай хамтран ажиллах.	I-VI сар	Зуухан цехийн дарга, Ахлах инженер, ЭХХМ	Зуухны суурилагдсан хүчин чадлыг 100Гкал-аар нэмэгдүүлж нэг зуухаар өргөтгөх ТЭЗҮ хийж дуусган ЭХЯ-аас 6-р сарын 12-нд шав тавих ёслол хийж, олон улсын тендер шалгаруулалтаар БНХАУ-ын компани шалгарч ажлын даалгаврын дагуу ажлын зураг хийж байна. Шаардлагатай баримт бичиг, зураг, схемийг бүрдүүлж өгөв.	100%
97	14	УБДС ТӨХК, УБТЗ ХНН-ээс авах ЦЭХ-ний тоолуурын заалт авч тооцоо хийх	Сар бүр	Эрчим хүчний хэмнэлтийн менежер	Сар бүрийн сүүлийн өдрөөр тоолуурын заалт авч, тооцоо нийлж ажиллалаг. 2022 онд 21.041.926 кВт цахилгаан хэрэглэсэн. Үйлдвэрлэсэн дулаандаа харьцуулахад /841,820т ккал/ цахилгаан эрчим хүчний хувийн зарцуулалт 34.50кВт.ц/ккал байна.	100%
98	15	УСУГ-тай усны тоолуураар тооцоо хийх	Сар бүр		2022 онд 21241 тонн УСУГ-н цэвэр ус хэрэглэсэн. Энэ нь нийт усны хэрэглээний 11%-ийг эзэлж байна. Огнох онд 22710 тонн буюу нийт усны хэрэглээний 10%-ийг УСУГ-аас худалдан авч зуухны технологийн хэрэгцээнд хэрэглэсэн	100%
99	16	Гүний худагнуудын усны тооцоо хийх, холбогдох газарт төлбөр хийх	Сар бүр		2022 онд 146812 тонн худгийн ус, 18360 тонн гол, хөрсний ус ашиглаж нийт усны хэрэглээний 89%-ийг өртөг багатай усаар хангаж хэрэглэсэн худгийн усны тооцоог БЗДТХ-тэй хийж, 10.4сая төгрөгийг ус ашигласны төлбөрт төлсөн	100%
100	17	Вагон жин, усны тоолуур, шатахуун түгээгүүрт СХЗГ-аар баталгаажуулалт хийлгэж гэрчилгээ авах	II-IX сар	Ахлах инженер	СХЗГ-ын байцаагч Батбаяраар вагон жингийн статик, динамик хэмжүүрийг ажилд оруулж тохируулга хийлгэж 2 удаа, шатахуун түгээгүүрт 2 удаа шалгуулж баталгаажуулав. Усны 5ш тоолуурт хугацаанд нь баталгаажуулалт хийлгэж гэрчилгээ авсан.	100%
101	18	Барилга байгууламжуудын цахилгаан, усны хэрэглээг хянах зорилгоор тоолууржуулах, цахилгаан, усны зарцуулалтанд норм тогтоож үр дүнгийн урамшуулалтай холбож дүгнэх журамд оруулах	III сараас	Эрчим хүчний хэмнэлтийн менежер	Цахилгаан, ус, дулааны хэрэглээг бүрэн тоолууртай ажилладаг. УБЦДҮС-тэй хамтраад 2022 оны 04-р сараас цахилгааны хэрэглээг бодит утгаар цаг бүрээр нь авч, өгөгдлийг боловсруулан цахилгаан ачааллын хэрэглээг хянан ажиллаж байна. Цех, алба хэлтсүүдийн үр дүн дүгнэх журамд оруулан ахлах инженерээр дүгнүүлдэг.	100%
102	19	Эрчим хүчний хэмнэлтийн төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг хангуулах, хөтөлбөрийн биелэлт гаргах	VI, XII сар		2022 оны эрчим хүчний хэмнэлтийн ажлын төлөвлөгөөнд нийт 18 ажил төлөвлөсөн. 88%-ийн гүйцэтгэлтэй биелсэн. Үүнээс 10 ажил 100%-ийн биелэлттэй, 7 ажил 80-90%-ийн биелэлттэй, Эрчим хүчний нж бүрэн аудит хийлгэх ажлыг эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас хойшлуулж 2023 оны төлөвлөгөөнд тусгасан.	100%
103	20	ЭХЗХ-нд тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлт гаргаж хүргүүлэх	Сар, улирал, жилээр	Ахлах инженер, Эрчим хүчний хэмнэлтийн менежер	Сар бүр тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтийг холбогдох хэлтэс, хэсгээр гаргуулан ажилласан.	100%
ТАВ. ХАНГАМЖИЙН ХЭЛТЭС						
104	1	2022 оны өөрийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг Гөрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу төлөвлөх, зохион байгуулах	I-IV сар		Амгалан дулаан станц ТӨХК-ийн 2022 оны техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтод түвшин батлах тухай, Эрчим хүчний сайдын А/21 тоот тушаал болон компанийн 2022 оны бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай А/04 тоот тушаалаар 79 нэр төрлийн 14,607,565,900 төгрөгийн бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан ажилласан байна	100%

105	2	2022 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг tender.gov.mn болон шилэн дансанд цаг тухайд нь байршуулах	Жилдээ	Хангамжийн хэлтсийн дарга, Хангамжийн ажилтан	2022 онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг tender.gov.mn байршуулан, цахим систем-ор тендер шалгаруулахт зохион байгуулах төсөл арга хэмжээг бүрэн зарласан, шилэн дансанд шаардлагатай 304 анны сонирхолын зөрчилгүйн мэдүүлэг үндэслэлтэй хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн 308 мэдэгдэлийг шилэн дансанд байршуулсан	100%
106	3	Жил, улирал, сарын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл гаргаж батлуулах, улирал, жилийн тайлан бичиж тайлагнах, баталгаажуулах	Тухай бүр		Улирал, сарын ажлын төлөвлөгөөг гарган батлуулж, гүйцэтгэл гаргаж танилцуулж, улиралын тайлан бичиж тайлагнаж, баталгаажуулсан	100%
107	4	Станцын горим, найдвартай үйл ажиллагаанд шаардлагатай бараа материалын шууд худалдан авалт хийх	Тухай бүр	Хангамжийн хэлтсийн дарга, Хангамжийн ажилтан	Худалдан авах төлөвлөгөөний дагуу 490,897,600 төгрөгийн шууд худалдан авалт хийсэн	100%
